



АЮУЛГҮЙ, АЗ ЖАРГАЛТАЙ БОГИНО ХЭМЖЭЭНИЙ КИНО УРАЛДААНЫ УДИРДАМЖ

1. УРАЛДААНЫ ЗОРИЛГО

Монгол Улсад жилд дунджаар 500-600 хүн зам тээврийн ослоор амия алдаж байна.

2019 онд 25,302 зам тээврийн осол бүртгэгдэж, 561 хүн зам тээврийн ослоор амия алджээ. Зам тээврийн ослын тоог бууруулах, жолооч нарыг замын хөдөлгөөнд соёлтой, зөв оролцохыг кино контентоор дамжуулан уриалах зорилготойгоор богино хэмжээний кино уралдааныг зохион байгуулж байна.

2. ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД

- Тоёота Сэйлс Монголиа ХХК
- Тээврийн цагдаагийн алба
- Монгол Контент ХХК

3. УРАЛДААНЫ ХУГАЦАА /шинэчлэгдсэн/

2021.06.21 – 2021.07.11-ний 23:59 минут хүртэл бүтээлүүдийг хүлээн авна.

2021.07.12 – 2021.07.14-нд уралдааны шаардлага хангасан бүтээлүүдийг зохион байгуулагчдын сошиал хуудсанд нийтэлнэ.

2021.07.15 - 2021.07.16-нд ‘Аюулгүй, Аз жаргалтай’ богино хэмжээний кино уралдаан”-ы шүүгчид уралдааны ялагчдыг тодруулна.

2021.07.17-нд ялагчдад шагналыг гардуулна.

4. ШАГНАЛЫН САН

- **ТЭРГҮҮН БАЙР:** 10 сая төгрөгийн эрхийн бичиг
- **II БАЙР:** 7 сая төгрөгийн эрхийн бичиг
- **III БАЙР:** 4 сая төгрөгийн эрхийн бичиг
- **ТУСГАЙ БАЙР:** 2 сая төгрөгийн эрхийн бичиг

/Уралдааны ялагчид шагналаа [DJI Mongolia](#), [PC MALL](#), [ITSTORE](#) дэлгүүрүүдээс сонгон авах боломжтой/

5. БҮТЭЭЛИЙН ТӨРӨЛ

Уралдаанд оролцогч нь дараах төрөл, жанрын аль нэг эсвэл хосолсон байдлаар бүтээлээ түүрвиж ирүүлэх боломжтой.

- Гэр бүлийн (Family film)
- Нөхөрлөлийн тухай (Buddy film)
- Аян замын (Road movie)
- Драма (Drama)
- Хүүхдийн кино (Children's movie)
- Анимэйшн (Animation)
- Романтик (Romance)
- Хөгжимтэй кино (Music movie)
- Детектив (Detective/Cop)



- Тагнуул/Тагнуулын үйл ажиллагаатай (Espionage)
- Адал явдал/Тулаантай (Action/Adventure)
- Шинжлэх ухааны уран зөгнөлт (Sci-Fi)
- Фантази (Fantasy)
- Эмгэнэлт инээдмийн (Dark Comedy)

Хөгжимтэй кино (*Music Movie*) төрөл нь *Musical* биш юм. Кинонд хөгжим, дуу орсон байх шаардлагатай. Жишээ нь: *Bohemian Rhapsody*, *Ray*, *Rocketman*, *Од ба гэрээ гэх мэт.*

6. АШИГЛАЖ БОЛОХГҮЙ КИНОНЫ ТӨРӨЛ

- Аймшиг (Horror)
- Сэтгэхүйн аймшиг/Триллер (Suspense/Thriller)

7. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Уралдааны удирдамжид **заасан төрөл, жанрын дагуу бүтээлээ хийсэн байх;**
- **3–7 минутын урттай байх**
- (3 минутаас бага эсвэл 7 минутаас их бол уралдааны шүүлтэд оруулахаас татгалзана);
- Уран бүтээлчдийн нэрс, продакшны лого нь киноны үргэлжлэх 3-7 минутад орохгүй ба үүнийг нэмэлтээр 1 минутад багтаан гаргах;
- Киноны эхлэлд дараах текстийг хар дэвсгэр дээр цагаанаар зайлшгүй гаргах
- “**Энэхүү киног “Аюулгүй, аз жаргалтай” бодино хэмжээний кино уралдаанд зориулан бүтээв**” эсвэл “**This film is made for the short film competition “Safe and Happy”**”
- Тоёота автомашины лого ямар нэг байдлаар гарч өнгөрөх;
- Тоёота брэндийн автомашин ‘**Аюулгүй, найдвартай**’ гэсэн утгыг тодорхой хэмжээнд харуулсан байх;
- LEXUS болон бусад машин үйлдвэрлэгчдийн логог оруулахаас **зайлсхийх**;
- Кинонд зөвхөн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй дүрс, хөгжим ашиглах;
- **FULL HD 1080.mp4** форматтай байх;

8. БҮТЭЭЛ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ

Уралдаанд оролцох бүтээлийг доорх форматын дагуу **2021 оны 7-р сарын 11-ний 23:59** цагаас өмнө хүлээж авна. Хоцорсон киног шүүлтэнд оруулцуулах боломжгүй.

Бүтээлийг хүлээлгэн өгөхдөө:

1. Кино нь **FULL HD 1920 x 1080** форматтай байх
2. **.mp4** форматтай байх
3. Формат таараагүй киног хүлээж авахгүй
4. “**БҮРТГЭЛИЙН ХУУДАС**”-ыг бөглөж, social@mongolcontent.mn хаягаар ирүүлэх
5. И-мэйлийн гарчгийг “**Аюулгүй, аз жаргалтай**” кино уралдаанд **[Оролцогчийн овог нэр]** гэсэн форматаар бичиж илгээх/
6. Бүтээлийг **TATAJ AVAX LINKE**-ийг заавал бичсэн байх
7. Киноны Stills image буюу **2-3 зураг** хавсаргах
8. Кино уралдаанд “**БҮРТГЭЛИЙН ХУУДАС**”-ыг бөглөж, баталгаажуулаагүй бүтээлийг шүүлтэд оруулахгүйг анхаарна уу!

9. ШАЛГАРУУЛАЛТ



Богино хэмжээний кино шалгаруулалт нь дараах 2 үе шаттай явагдах ба эдгээр үнэлгээний нийлбэрээр Шагналт байрыг тодорхойлно.

Үзэгчдийн үнэлгээ (30%) + Шүүгчдийн онооны нийлбэр (70%) = Нийт үнэлгээ

9.1. ҮЗЭГЧДИЙН ҮНЭЛГЭЭ

Уралдааны шаардлагыг хангасан бүтээлүүдийг дараах Сошиал хуудсанд **2021.07.12-2021.07.14**-нд уралдааны зохион байгуулагчдын дараах хуудсуудад нийтлэх ба **зөвхөн дараах хуудсанд нийтэлсэн бүтээлүүдийн лайк, шэйр, комментийн нийлбэр оноо нийт шүүлтийн 30%-д нөлөөлнө.**

- <https://www.facebook.com/toyota.mongolia>
- <https://www.facebook.com/zamiintsagdaa>
- <https://www.facebook.com/gogo.mn>

Бүтээлүүдийг нийтлэхдээ дараах хашtag-тайгаар нийтэлнэ.

#Аюулгүй, АзЖаргалтайКиноУралдаан, #Тоёота

9.2. ШҮҮГЧДИЙН ҮНЭЛГЭЭ

Шүүгчид уралдаанд оролцогчдын бүтээлд дараах шалгуур үзүүлэлт бүрээр тус бүр 0-10 оноог өгч, нийт дүнг гаргах ба **шүүгчдийн нийлбэр оноо** нь шүүлтийн 70%-д нөлөөлнө.

1. Уралдааны шаардлагыг хангасан байдал
2. Техник чадвар (зураг авалт, эвлүүлэг)
3. Ур чадвар (жуужиглэлт, найруулга, хөгжим)

10. БҮТЭЭЛД ХӨГЖИМ, ДҮРС АШИГЛАХДАА АНХААРАХ ЗҮЙЛС

“Аюулгүй, аз жаргалтай” богино хэмжээний кино уралдааны кино бүтээлд ашиглах хөгжим нь оюуны өмч болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай.

1. Бүтээлд ашиглах хөгжим нь **зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай** бөгөөд хөгжмийн зохиолчтой гэрээ байгуулан бүтээлд ашиглана. Эсвэл кинондоо зориулан цоо шинээр хөгжим зохиолгон ашиглаж болно. Киногоо хүлээлгэж өгөхдөө хөгжмийн зохиолчтой хийсэн гэрээний нэг (1) хувийг хавсаргасан байх;
2. Кинондоо зориулан уран бүтээлч нь цоо шинээр өөрөө хөгжим зохиосон бол өөрөө зохиосноо батлан, **БАТЛАМЖ** гаргаж гарын үсэг, компаний тамгаар баталгаажуулан нэг (1) хувийг хавсаргасан байх шаардлагатай;
3. Кинондоо зориулан **онлайнаар хөгжим авсан тохиолдолд** худалдан авсан баримтын хуулгын нэг (1) хувийг хавсаргасан байх шаардлагатай;
4. Кинондоо зориулж **Royalty Free** хөгжмийг зориулалтын цахим хуудаснаас татах авсан тохиолдолд тухайн цахим хуудасны Үнэгүй хэрэглэж болно гэсэн заалтыг хэвлэн авч нэр (1) хувийг хавсаргасан байх шаардлагатай;
5. Кинондо ашиглах дүрс, графикууд оюуны өмчийн зөвшөөрөлтэй байх шаардлагатай;
6. Youtube, Facebook, Vimeo, Spotify гэх мэт сошиал платформоос **зориулалтын бус аргаар татах авсан хөгжим, дүрсийг хэрэглэж болохгүйг** хатуу анхаарна уу!
7. Хөгжмийг зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэйгээр авч кинондоо ашигласан гэдгээ кино хүлээлгэж өгөх үед баталж чадаагүй тохиолдолд киног шалгаруулалтад оруулахгүйг анхаарна уу!

Холбоо барих:

social@mongolcontent.mn



**АЮУЛГҮЙ, АЗ ЖАРГАЛТАЙ
БОГИНО ХЭМЖЭЭНИЙ КИНО УРАЛДААНЫ БҮРТГЭЛИЙН ХУУДАС**

1. Уралдаанд оролцогч та энэхүү бүртгэлийн хуудсыг бөглөж, холбогдох хавсралтын хамт social@mongolcontent.mn хаягаар **2021 оны 7 дугаар сарын 11**-ны 23:59 цагаас өмнө илгээнэ үү.
 2. И-мэйлийн гарчгийг “**Аюулгүй, аз жаргалтай**” кино уралдаанд [**Оролцгчийн овог нэр**] гэсэн форматаар бичсэн байх ёстойг анхаарна уу.
 3. Бутээлд хавсаргасан байх шаардлагатай дараах зүйлс бүрэн эсэхийг илгээхийн өмнө сайтар нягтална уу.

| КИНОНЫ МЭДЭЭЛЭЛ

1. Бүтээлийн нэр:
.....
 2. Төрөл жанр:
.....
 3. Үргэлжлэх хугацаа:мин.....сек
 4. Товч агуулга:

5. Бүтээлд ашигласан хөгжим, дууны мэдээлэл:

Дууны нэр:

Үг. ая зохиогч:



Бүтээлд ашигласан хөгжим, дурс нь таны бүтээл бол баталгаажуулах баримт бичгийг хавсаргана уу.
Хэрэв бүтээлд ашигласан хөгжим, дурс нь таны бүтээл биш бол албан ёсоор **худалдан авсан баримт** эсвэл **зохиогчийн эрхийн зөвшөөрлийг** хавсаргана уу.

6. Уралдаанд оролцох бүтээлийн **ТАТАЖ АВАХ ЛИНК**-ийг бичнэ үү. /заавал бичих/

.....
.....
.....
.....

НАЙРУУЛАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Овог:

Нэр:

Хүйс:

Утас:

Цахим шуудан:

Хаяг:

Найруулагчийн зураг: /хавсралтаар оруулна уу./

Нэмэлт мэдээлэл:

ХОЛБОО БАРИХ ХҮНИЙ МЭДЭЭЛЭЛ:

Овог:

Нэр:

Хүйс:

Утас:

Цахим шуудан:



Хаяг:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Энэхүү анкетыг баталгаажуулахын өмнө таны бүтээл уралдааны шаардлагыг хангаж буй эсэхийг сайтар нягтална уу.

ХАВСАРГАХ ЗҮЙЛС

- Иргэний үнэмлэхний хуулбар
- Найруулагчийн зураг
- Бүтээлийг **ТАТАЖ АВАХ ЛИНК**
- Бүтээлийн **2-3 ш зураг**
1920*1080 хэмжээтэй байх
.png, .jpg, .jpeg форматтай байх
- Бүтээлд ашигласан хөгжим дуу нь зохиогчийн эрхийн зөрчилгүй батлах баримт

Энэхүү анкетыг бөглөж гарын үсэг зурснаар, би кино уралдааны удирдамжтай танилцаж, уралдааны шаардлагад нийцсэн, оюуны өмч, зохиогчийн эрхийн зөрчилгүй бүтээл гэдгийг баталж байгаа ба уралдааны зохион байгуулагчдын мэдээллийн болон сошиал хуудсуудад байршуулан олны хүртээл болгохыг хүлээн зөвшөөрч байгаа болно.

.....
Гарын үсэг

.....
Огноо